



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 08 сарын 10 өдөр

Дугаар А/162

Мандалговь

Хот тохижуулах газрын албан хэрэгцээнд
хог зөөврийн машин нийлүүлэх ажлыг
хүлээлцэх комисс томилох тухай

Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 11.4, 16.3 дугаар заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй “Хот тохижуулах газрын албан хэрэгцээнд хог зөөврийн машин нийлүүлэх” ажлыг хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Д.Очбадрах (Хот тохижуулах газрын дарга)

Нарийн бичгийн дарга: Д.Мөнхцоож (Хот тохижуулах газрын ахлах мэргэжилтэн)

Гишүүд: Ж.Уянга (Аймгийн Засаг даргын тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)

Ж.Базарсад (Хот тохижуулах газрын хог хариуцсан инженер)

Н.Жамъянхорол (“Түшигмандал” ХХК-ний менежер)

2. Хот тохижуулах газрын албан хэрэгцээнд хог зөөврийн машин нийлүүлэх ажлыг хүлээн авч, холбогдох баримт бичгийг бүрдүүлэн ажиллахыг комиссын дарга (Д.Очбадрах)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Л.ДОРЖБАТ



486210781

Боловсруулсан: *М. Чам У*
Хянасан: *Н. Ардмт Оюу*
1985